

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
“БУЛГАНЫ СЭРГЭЛТ” ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ХИЙСЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2025.12.01

Булган

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Булганы сэргэлт” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хөтөлбөрийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн үр дүн болон зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үр дүнтэй байсан эсэхэд үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 25, хөтөлбөрийн 44 үр дүн, 151 үйл ажиллагааны 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд 344 шалгуур үзүүлэлтийн дагуу 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх” журмыг баримтлан хяналт-шинжилгээ хийлээ.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт 2025 оны жилийн эцсийн байдлаар төсвийн ерөнхийлөн захирагчийн 25 үр дүнгийн хэрэгжилт 63.7 хувь, хөтөлбөрийн 44 үр дүнгийн хэрэгжилт 77.4 хувь, 151 үйл ажиллагааны хэрэгжилт 82.3 хувьтай хэрэгжсэн байна. Мөн нийт батлагдсан 344 шалгуур үзүүлэлт тус бүрээр зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ хийхэд төсвийн ерөнхийлөн захирагчийн 9 шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийн 23 шалгуур үзүүлэлт, үйл ажиллагааны 47 шалгуур нийт 79 шалгуур үзүүлэлт буюу 22.9 хувь нь удаашралттай байна.

Хөтөлбөрийн хүний хөгжлийн сэргэлт бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн 8 үр дүнгийн хэрэгжилт 91.1 хувь, эдийн засгийн сэргэлт бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 үр дүнгийн хэрэгжилт 54.1 хувь, бүсчилсэн хөгжилд Булганы сэргэлт бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 үр дүнгийн хэрэгжилт 45.6 хувь, засаглалын бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн 7 үр дүнгийн хэрэгжилт 64.0 хувьтай байна.

Хүний хөгжлийн сэргэлт бодлогын хөтөлбөрийн 17 үр дүнгийн хэрэгжилт 75.8 хувь, эдийн засгийн сэргэлт бодлогын хөтөлбөрийн 13 үр дүнгийн хэрэгжилт 68.2 хувь, бүсчилсэн хөгжилд Булганы сэргэлт бодлогын хөтөлбөрийн 5 үр дүнгийн хэрэгжилт 88.3 хувь, засаглалын бодлогын хөтөлбөрийн 9 үр дүн 77.1 хувьтай тус тус хэрэгжжээ.

Дээрх үр дүнгүүдийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 151 үйл ажиллагаанаас хүний хөгжлийн сэргэлт бодлогын 53 үйл ажиллагаа 79.4 хувь, эдийн засгийн сэргэлт бодлогын 50 үйл ажиллагаа 80.0 хувь, бүсчилсэн хөгжилд Булганы сэргэлт бодлогын 25 үйл ажиллагаа 86.9 хувь, засаглалын бодлогын 23 үйл ажиллагаа 83.1 хувьтай тус тус хэрэгжсэн. Үйл ажиллагааны хэрэгжилтийг нарийвчлан авч үзвэл 85-аас дээш хувьтай хэрэгжсэн 89, 60-85 хүртэл хувьтай хэрэгжсэн 24, 30-60 хүртэл хувьтай хэрэгжсэн 9, 0-30 хүртэл хувьтай хэрэгжсэн 17, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 12 ажил байна. Дээрхи хэрэгжилт удааширсан 26 арга хэмжээг эхний хагас жилийн гүйцэтгэл, үр дүнтэй харьцуулж үзвэл удааширсан заалтын тоо 57.7 хувиар буурсан үр дүнтэй байна. Тухайлбал төсөв, санхүүжилтээс шалтгаалж удааширсан заалт 64.2 хувиар, удирдлага зохион байгуулалтаас шалтгаалсан заалт 60.1 хувиар тус тус буурсан бол гүйцэтгэлээс шалтгаалж удааширсан арга хэмжээний хувь өөрчлөлтгүй байна.

2025 оны байдлаар төсөв санхүү, удирдлага арга зүй, гүйцэтгэлээс шалтгаалж хэрэгжилт нь удааширсан 26 ажлуудыг дурдвал:

Гүйцэтгэлээс шалтгаалж үр дүн хүлээгдсэн:

1. Эрүүл мэнд салбарын 1.1.1.2 Хүн амын дундах зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулна.
2. Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбар 1.3.2.2 Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн (эрэгтэй, эмэгтэй) эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулна.
3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбар 1.3.2.3 Хүүхэд, гэр бүл, залуучуудын салбарын барилга байгууламжийн өргөтгөл шинэчлэл, засварын ажлыг хэрэгжүүлнэ.
4. Аялал жуулчлалын салбар 1.8.1.1 Аялал жуулчлалын В, С зэрэглэлийн зам дагуу амрах өртөө, зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг байгуулна.
5. Аялал жуулчлалын салбар 1.8.1.3 “Нэг өрх- Жуулчин гэр” НИТАЖ төслийг хэрэгжүүлнэ.

6. Байгаль орчны салбарын 2.5.2.3 Хүн амын баталгаат усан хангамжийг сайжруулна.
7. Байгаль орчны салбарын 2.5.3.4 Цөлжилттэй тэмцэх, сэргийлэх, сааруулах зорилгоор элсний нүүдлийг тогтоон барих ойн хамгаалалтын зурвас болон механик хамгаалалт байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
8. Байгаль орчны салбарын 2.5.4.2 Сумдыг хог ангилан ялгах хогийн саваар үе шаттайгаар хангана.

Төсөв, санхүү:

1. Аялал жуулчлалын салбар 1.8.1.7 Аялал жуулчлалын бүсэд орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг худалдаалах нөхцөлийг бүрдүүлнэ.
2. ХАА-н салбарын 2.4.2.2 Мал эмнэлгийн салбарын чанар хүртээмж, үр дүнг сайжруулна. төсөв
3. ХАА-н салбарын 2.4.1.8 Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор үржлийн нэгжүүдийг Бүрэгхангай, Дашинчилэн, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр суманд байгуулна.
4. Байгаль орчны салбарын 2.5.2.4 Булган аймгийн усны нөөц, нийгэм эдийн засгийн салбаруудын усны эрэлт, усны балансын үнэлгээ хийнэ.
5. Байгаль орчны салбарын 2.5.2.5 Усны менежментийн болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний төлөвлөлт хийнэ.
6. Байгаль орчны салбарын 2.5.2.1 Гадаргын усны нөөцийг хуримтлуулна.
7. Газар зохион байгуулалтын салбарын 3.1.1.1 Аймгийн хэмжээнд 8 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна. /Бугат, Орхон, Тэшиг, Хутаг-Өндөр, Дашинчилэн, Хангал, Хишиг-Өндөр, Сэлэнгэ/
8. Хууль, эрх зүйн салбарын 4.2.1.2 Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулж сургалт, дадлага зохион байгуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг ажиллах нөхцөлөөр хангаж техник, зэвсэглэмжийг нэмэгдүүлнэ.
9. Батлан хамгаалах салбарын 4.3.1.3 Орон нутаг дахь Зэвсэгт хүчний алба хаагчдын эрүүл, тогтвортой ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Удирдлага, зохион байгуулалт:

1. Боловсролын салбар 1.2.3.5 Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог улсын дунджаас нэмэгдүүлнэ.
2. Боловсролын салбар 1.2.3.3 Бага боловсролыг дэмжих “Амжилтын гараа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3. Боловсрол салбарын 1.2.1.1 Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэн хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ.
4. Соёл, урлагийн салбар 1.7.1.2 Шилдэг бүтээл болон улсын, олон улсын чанартай уралдаан, тэмцээнд онцгой амжилт гаргасан орон нутгийн уран бүтээлчдийг шагнаж урамшуулах бодлого баримтална.
5. Аялал жуулчлалын салбар 1.8.1.2 Хөвсгөл, Булган, Орхон аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан Дархадын хотгор, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав дагуух экосистемд түшиглэсэн байгалийн олон төрөлт аяллын чиглэлийг хөгжүүлэх "ХӨХ БААВГАЙ" аялал жуулчлалын кластерт нэгдэнэ.
6. ХАА-н салбарын 2.4.1.6 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.
7. Байгаль, орчны салбарын 2.5.2.2 Усны сан (булаг шанд, гол горхи, нуур тойром, рашаан) бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ.
8. Байгаль, орчны салбарын 2.5.3.3 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд жилд 1.5 саяас доошгүй ширхэг мод, бут, сөөг тарьж ургуулна.
9. Засаглалын сэргэлт бодлогын 4.5.1.1 Аймгийн 90 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах 90 бүтээлч ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт" хөтөлбөрийн хэрэгжилтэд үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ.

Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн 113 үйл ажиллагаа буюу 81.3 хувь нь "Үр дүнтэй" болон "Үр дүн хүлээгдэж байгаа" бол 26 үйл ажиллагаа буюу 18.7 хувь нь үр дүн хангалтгүй байна. Нийт батлагдсан шалгуур үзүүлэлтийн 77.03 хувь хэрэгжсэн буюу зорилтод түвшинг хангасан байна.

Хүний хөгжлийн сэргэлт бодлогын төсвийн ерөнхийлөгчийн захирагчийн үр дүн хамгийн өндөр буюу 91.1 хувьтай байх бол Эдийн засгийн сэргэлт, Бүсчилсэн хөгжилд Булган сэргэлт бодлогуудын үр дүнгүүд хангалтгүй үнэлгээтэй боловч Хөтөлбөрийн үр дүнгээр авч үзвэл Бүсчилсэн хөгжилд Булган сэргэлт, Хүний хөгжлийн сэргэлт, Засаглалын сэргэлт бодлогуудын хөтөлбөрийн үр дүн "үр дүнтэй" болон "үр дүн хүлээгдэж байгаа" эерэг үзүүлэлттэй байна.

Үйл ажиллагааны үр дүнг салбар тус бүрээр авч үзвэл Хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн халамж, хамгаалал, Соёл, спорт, Уул уурхай, Зам тээвэр, Үйлдвэрлэл үйлчилгээ, Барилга, хот байгуулалт, Эрчим хүч, Хууль, эрх зүй, Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба, Гадаад харилцааны салбарууд 85-аас дээш хувьтайгаар “Үр дүнтэй” байх бол Гэр бүл, хүүхэд залуучууд, Байгаль орчны салбарууд 60 хүртэлх хувьтайгаар “үр дүн хангалтгүй” байна. Бусад салбарууд 60-аас 85 хүртэлх хувьтай “Үр дүн хүлээгдэж байгаа” үзүүлэлттэй байна.

Мөн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцох явцад хэлтэс, сумд агентлагууд дараах нийтлэг алдаа, дутагдалыг гаргасаар байна. Тухайлбал:

-Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд үндсэн болон хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан хэлтэс, сум, байгууллагууд хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллаагүй;

-Үр дүн, үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу үр дүнг зорилтот түвшинд хүргэхээр зохион байгуулалтын ажлыг батлагдсан журам, аргачлалын дагуу хийгээгүй;

-Хэрэгжилт дэх тоон ба статистик мэдээллүүд нотлох баримтаар нотлогдохгүй байх, хэлтэс, сумд, агентлагуудын мэдээ, мэдээлэл зөрүүтэй, хувийг хэт өсгөх, хийсвэрээр тоо, дүн мэдээг гаргасан;

-Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлээгүй, гүйцэтгэлд төлөвлөгөөний дагуу хяналт тавиагүй зэрэг асуудлууд байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ /Зөвлөмж/

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, харьяа байгууллагууд, сумд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, зохион байгуулалтыг эрчимжүүлэн, хэрэгжилтийг хангах;

-Хэрэгжилтийг тайлагнахдаа зорилтот түвшинд хүрсэн эсэхийг нотлох баримтын хамт тайлагнах, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхойлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах;

-Сум, байгууллагуудаас тайлан мэдээг нь татан авч, мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах;

-Оны эцэст статистик мэдээлэлд үндэслэж хэрэгжилтийн үнэлгээ гарах ажлууд, төсөв, хөрөнгө оруулалт шийдэгдсэн хэр нь ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах зэрэг удаашралтай ажлуудын хэрэгжилтийг эрчимжүүлж, хэрэгжилтийг яаралтайгаар зохион байгуулж үр дүнд хүргэх;

-Дүгнэлт хэсэгт дурдагдсан хэрэгжилт хангалтгүй байгаа ажлуудын гүйцэтгэлийг эрчимжүүлэхэд онцгойлон анхаарч, 2025 оны үр дүн, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулан, зорилтот түвшинд хүргэх шаардлагатай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС